

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 33 ДУГААР ХУРАЛДААНЫ ТОЙМ

Хуралдаан 2013 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 14 цаг 00 минутад эхэлж, 15 цаг 51 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 51 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Зарим удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргуулах тухай</p> <ul style="list-style-type: none">- Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газрын Сургалт, сурталчилгаа, олон нийттэй харилцах хэлтсийн дарга	<p>Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none">1. Лхамын Лувсанжамцыг Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх.2. Энэ тогтоолын нэгдүгээрт нэр заасан иргэн Лхамын Лувсанжамцыг Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Ш.Булга-Эрдэнэд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. <p>Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны</p>

		<p>шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Дашнамжилын Тэгшдэлгэрийг Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газрын Сургалт, сурталчилгаа, олон нийттэй харилцах хэлтсийн даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх</p> <p>2. Энэ тогтоолын нэгдүгээрт нэр заасан иргэн Дашнамжилын Тэгшдэлгэрийг Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газрын Сургалт, сурталчилгаа, олон нийттэй харилцах хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Худалдан авах ажиллагааны газрын дарга Д.Энхжаргалд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи шуудан, харилцаа холбооны газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай</p>	<p>Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэгийн 2013 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн ХЭГ/1792 тоот албан бичиг, Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу сонгон шалгаруулалтыг 2013 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2013 оны 12 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд зохион байгуулахаар тогтлоо.</p>

3	<p>Тогтоол хүчингүй болгох тухай /Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргад Г.Наранцэцэгийг нэр дэвшүүлсэн тогтоолыг хүчингүй болгох/</p>	<p>Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 5.1.6 дахь заалтыг баримтлан Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1.Үйлдвэр хөдөө аж ахуйн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд Гантөмөийн Наранцэцэгт “Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гарган нэр дэвшүүлсэн “Нэр дэвшүүлэх тухай” Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 173 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох.</p> <p>2.Энэ тогтоолыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Золжаргал болон нэр дэвшигч Г.Наранцэцэг нарт хүргүүлэхийг Ажлын албаны дарга С.Цэдэндамбад үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	<p>Архангай аймагт зохион байгуулсан төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2013 оны 11 дүгээр сарын 11-ээс 11 дүгээр сарын 15-ны өдрүүдэд Архангай аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Архангай аймагт 2013 оны 11 дүгээр сарын 11-ээс 11 дүгээр сарын 15-ны өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн</p>

		<p>шалгалтад тэнцсэн нийт 36 иргэнээс 27 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 9 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэснийг 1, 2 дугаар хавсралтаар тус тус батлах.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 14 иргэнийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 3 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлж, нэрсийг 3, 4 дүгээр хавсралтаар тус тус батлах.</p> <p>3. Энэхүү тогтоолын 3, 4 дүгээр хавсралтаар баталсан нэр бүхий 17 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Архангай аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргад үүрэг болгох.</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--	---

5	<p>Бусад асуудал /УИХ-ын Тамгын газрын зарим удирдах албан тушаалд томилуулахаар санал болгосон албан хаагчдад Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай/</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн даргын албан тушаалд Насангийн Цогтсайханд дүгнэлт гарган нэр дэвшүүлж, томилуулахаар Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатарт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль зүйн үйлчилгээний хэлтсийн орлогч даргын албан тушаалд Ламжавын Батжавт дүгнэлт гарган нэр дэвшүүлж, томилуулахаар Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатарт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
---	---	--

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

